



ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: lkhterbum@gmail.com

“Жуулчин дюти фрий” ХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд болон
төлөөлөн удирдах зөвлөлд

2024 05 28 № 24/52
танай _____ -ны № _____ т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Жуулчин дюти фрий” ХК (цэшид “Комиши” гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын лагуу үнэн зөв, болитой илрүхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариушлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайланд аудиторын хүлээх үүрэг хариушлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ес Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЕЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ес Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЕЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохицтой гэж бид найдаж байна.

Бусад мэдээлэл

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”), хэрвээ байхгүй бол гүйцэтгэх удирдлага нь бусад мэдээллийг бэлтгэх үүрэгтэй. Бусад мэдээлэл нь ТУЗ-ийн тайлангийн хавсралт, бизнесийн хариуцлагын тайланг багтаасан мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбогдуулан бидний үүрэг бол бусад мэдээлэлтэй танилцах бөгөөд бусад мэдээлэл нь бие даасан санхүүгийн тайланд эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх талаар авч үзэх явдал юм. Энэ талаар бидэнд мэдээлэх зүйл байхгүй болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“Жуулчин дюти фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд болон ТУЗ-д

Санхүүгийн тайландаа удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг алдаатай илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайлан гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс оор сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагнанын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бухэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлдэг гэсэн баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайландаа үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нелөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиландаа, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нохцэл байдалд тохирох аудитын горим боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг авч үздэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсэх үйл явдал, нохцэл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“Жуулчин дюти фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд болон ТУЗ-д

түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангах хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94 дүгээр зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зовхон Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын омно хариуцлага хүлээхгүй.

Д.Даншулам - Гүйцэтгэх захирал
“Шинэ ИХ Гэрбүр аудит” ХХК
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 11-р хорболол, Залуучуудын оргон чолоо
North center, 204 тоот

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

(Төгрөгөөр)

ХӨРӨНГӨ

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

	<i>Лав</i>	2023/12/31	2022/12/31
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	5	292,559,555	39,161,715
Дансны авлага	6	3,269,949	6,510,265
Татвар, НДШ-ийн авлага	7	5,616,400	11,993,413
Бусад авлага	8	2,832,779,742	2,450,135,051
Бараа материал	9	706,155,898	888,454,937
Урьдчилж төлсөн зардал (тооцоо)	10	10,153,129	10,695,021
Эргэлтийн хөрөнгийн дүн		3,850,534,672	3,406,950,402

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө	11	192,873,608	216,628,358
Бист бус хөрөнгө	12	2,434,980	3,701,030
Хойшлогдсон татварын хөрөнгө	13	34,653	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		195,343,241	220,329,389

НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН

4,045,877,913

3,627,279,791

ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТОЛБОР

Дансны оглог	14	22,099,770	2,121,807
Цалингийн өглөг	15	13,677,221	8,410,309
Татвар, НДШ-ийн өглөг	16	38,061,688	10,821,354
Ногдол ашигийн өглөг	17	977,156,755	977,156,755
Урьдчилж орсон орлого	18	333,537	-
Нөөц /өр төлбөр/	19	-	1,200,000
Бусад богино хугацаат өр төлбөр	20	3,146,276	8,529,123
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,054,475,247	1,008,239,349

ҮРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Хойшлогдсон татварын хөрөнгө	21	-	38,803,778
Үрт хугацаат өр төлбөрийн дүн		-	38,803,778
Нийт өр төлбөрийн дүн		1,054,475,247	1,047,043,126

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Хувь нийлүүлсэн хөрөнгө	22	13,072,400	13,072,400
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	23	2,978,330,266	2,567,164,265
Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүн		2,991,402,666	2,580,236,665

ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН

4,045,877,913

3,627,279,791

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

(Төгрөгөөр)

	<u>Лав</u>	<u>2023/12/31</u>	<u>2022/12/31</u>
Борлуулалтын орлого	24	1,605,749,728	392,406,829
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	25	762,701,099	200,587,968
Нийт ашиг		843,048,629	191,818,861
Хүүний орлого	26	287,313,919	-
Бусад орлого	27	2,733,128	5,921,684
Еренхий удирдлагын зардал	28	315,838,542	139,596,037
Борлуулалт маркетингийн зардал	29	182,997,083	96,947,752
Валютын ханшийн зөрүүгийн олз/гарз/	30	(192,908)	398,327,119
Бусад зардал	31	197,518,563	963,651
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	32	-	583,663
Татварын өмнөх ашиг (алдагдал)		436,548,581	359,143,886
Орлогын татварын зардал	33	25,382,580	38,754,022
Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)		411,166,002	320,389,864
Бусад дэлгэрэнгүй орлого			
Тайлант жилийн нийт ашиг (алдагдал)		411,166,002	320,389,864

Хавсаргасан тодруулга нь энхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувийн өмч	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт өмчийн дүн
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	13,072,400	2,246,774,400	2,259,846,800
Тайлант үсийн цэвэр ашиг (алдагдал)		320,389,864	320,389,864
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	46,270,974	2,567,164,265	2,580,236,665
Тайлант үсийн цэвэр ашиг (алдагдал)		411,166,002	411,166,002
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	46,270,974	2,978,330,266	2,991,402,666

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023/12/31	2022/12/31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,568,816,144	384,126,270
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,556,300,916	205,018,687
Бусад	12,515,229	179,107,583
Мөнгөн зарлагын дүн (-)	1,194,892,195	190,295,768
Ажиллагчдад олгосон мөнгө	111,044,087	58,785,191
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	54,875,155	22,853,158
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	907,381,572	247,500
Түүлиш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,000	15,305,240
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,360,000	2,395,500
Төлсөн татвар	20,561,135	2,269,721
Бусад мөнгөн зарлага	99,650,246	88,439,458
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	373,923,949	193,830,502
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	7,625,927,651	3,875,000
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	3,875,000
Хүлээн авсан хүүний орлого	245,610,594	
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	7,380,317,057	
Мөнгөн зарлагын дүн (-)	7,747,948,638	106,454,336
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,881,554	100,632,517
Биет бус хөрөнгө худалдан авсан	-	5,821,819
Бусдад олгосон зээл урьдчилгаа	7,744,067,084	
Хоронгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн	(122,020,987)	(102,579,336)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	179,103,359
Зээл өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	179,103,359
Мөнгөн зарлагын дүн (-)	-	260,585,238
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	240,157,750
Ногдол ашгийн төлбөрт төлсөн	-	20,427,488
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(81,481,879)
Валютын ханшийн зоруу	1,494,878	
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	253,397,840	9,769,287
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний улдэгдэл	39,161,715	29,392,428
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн улдэгдэл	292,559,555	39,161,715

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салигүй хэсэг болно.

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

1. Компанийн талаарх мэдээлэл

“Жуулчин дюти фрий” ХК нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн дагуу хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан Монгол улсын хуулийн этгээд бөгөөд 2006 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын бүртгэлд 9010001026 тоот гэрчилгээ, 2097893 тоот регистртэй бүртгэгдсэн.

Компанийн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшилийн хувь	Хувьцааны тоо	Нэгжийн унэ	Нийт дун
Том хувьцаа эзэмшигчид (5%-наас дээш)					
1	Таванбогд Холдингс ХХК	70.92%	46,355	100	4,635,500
2	Радар фонд ХХК	8.23%	5,379	100	537,900
Жижиг хувьцаа эзэмшигчид (5%-наас тооощ)					
3	Жижиг хувьцаа эзэмшигчид	20.85%	13,628	100	1,362,800
4					
	Нийт	100	65,362		6,536,200

Үйл ажиллагааны чиглэл:

Компанийн дүрэмд зааснаар

- Гадаад, дотоод худалдаа
- Хүнсний дэлгүүр /согтууруулах ундаагаар үйлчилэх/
- Татваргүй барааны дэлгүүр
- Үл хөдлөх хөрөнгийн түрээс
- Аялал жуулчлал
- Гадаад харилцаа
- Автомашин болон автомашины сэлбэгийн худалдаа
- Хүнсний бөөний худалдаа эрхлэх үйл ажиллагаа явуулдаг.

Бизнесийн үндсэн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Чингисийн өртөн чөлөө-6, Хаанбанк төвөр, 9 давхар

Утас: 99109571

Цахим хуудас: www.dutyfree.mn

И-мэйл хаяг: jdf.operations@tavanbogd.com

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

2.1 Тайлланг бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр толилуулсан. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд төгрөгөөр тайлагнасан.

2.2 Тасралтгүй үйл ажиллагаа

Компани одоо болон алс ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлийн гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн уйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Төсөөлөл, тооцооллуудын үнэлгээг байнга хийх ба эдгээр нь удирдлагын туршлага болон тухайн нехцэл байдлын хувьд ирээдүйд тохиолдож болохуйц хүлээлт зэрэг хүчин зүйлүүд дээр суурилдаг.

2.4 Бодит унэ цэнийн хэмжилт

Санхүүгийн тайланд хэд хэдэн хөрөнгө, өр төлбөрийг бодит унэ цэнээр нь хэмжиж, тодруулахыг шаарддаг. Компани санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит унэ цэнийн хэмжилтийг боломжит хэмжээнд хэрэглэдэг.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоох үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит унэ цэнийг хэмжинэ.

Санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит унэ цэнийн түвшинд дараах байдаар ангилсан ба ангилахдаа бодит унэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

- Түвшин 1 – хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх унэ,
- Түвшин 2 – шууд болон шууд бусаар ажиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит унэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх үнэлгээний техникиуд
- Түвшин 3 – ажиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит унэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй үнэлгээний техникиуд

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон толилуулгад орсон өөрчлөлтүүд

Компани 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд туштай мөрдөж байгаа болно.

Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон стандартын тайлбарууд

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтууд
2023.01.01	СТОУС 17 – Даатгалын гэрээ Энэхүү стандартын гол зорилго нь даатгалын гэрээг үнэн зөв илэрхийлэх, холбогдох мэдээллийг аж ахуйн нэгж бэлтгэдэг эсэхийг ханган магадлахад оршино. Энэ мэдээлэл нь аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тухайн даатгалын гэрээний үзүүлэх үр нөлөөг санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар үнэлэх суурь үндэслэлээр хангадаг.
2023.01.01	СТОУС 17 – Даатгалын гэрээ СТОУС-17-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2023.01.01	<i>НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолтын нэмэлт өөрчлөлт</i>
2023.01.01	<i>НББОУС-12 Орлогын албан татвар Хойшлогдсон татварын хөрөнгийн өөрчлөлт</i>
2023.01.01	<i>НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын өөрчлөлт</i>
2023.01.01	<i>НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга Эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгийн ангиллын өөрчлөлт</i>
2023.01.01	<i>НББОУС 12 Орлогын албан татвар - Нэг удаагийн гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татварын нэмэлт өөрчлөлт</i>
2023.05.23	<i>НББОУС 12 Орлогын албан татвар – Олон улсын татварын шинэчлэл – Хоёрдугаар тулгуур загварын дурмийн нэмэлт өөрчлөлт</i>

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2024.01.01	<i>СТОУС-16 Турээс Борлуулах ба буцаан түрээслэхтэй холбоотой хувьсах төлбөрийн өөрчлөлт</i>
2024.01.01	<i>НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал, эргэлтийн бус өр төлбөрийн гэрээгээр хүлээх урэг хариуцлагын талаарх өөрчлөлт</i>
2024.01.01	<i>НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалтын нэмэлт өөрчлөлтүүд</i>
2024.01.01	<i>СТОУС-ТБ1 Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлага</i>
2024.01.01	<i>СТОУС-ТБ2 Уур амьсгалтай холбоотой тодруулга</i>
2025.01.01	<i>НББОУС 21 Гадаад валютын ханшийн үр нөлөө Арилжааны алдагдлын талаарх нэмэлт өөрчлөлт</i>

Дээрх шинэ болон шинэчлэгдсэн зарим СТОУС-ын хэрэгжилт нь компанийн санхүүгийн үр дүнд ирээдүйд нөлөө үзүүлж болзошгүй гэж урьдчилан таамаглаж байна.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

4.1 Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.

Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат ор төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшуулах нехцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

4.2 Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө, түүнтэй адилтгах зүйлс, дансны ба бусад авлага, үнэт цаас, дансны ба бусад өглөг зэргээс бүрддэг. Компани санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзээ.

Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь төгрөг болон гадаад валютаар илэрхийлэгдэх гар дээрх бэлэн мөнгө, банкин дахь харилцах дансдаас бүрддэг.

4.2.1 Дансны ба бусад авлага

Авлагыг анх нэхэмжилсэн дүн буюу хүлээн авах мөнгөний дүнгээр бүртгэлд тусгана. Худалдан авагчдад худалдааны хөнгөлөлт болон бэлэн мөнгөн хөнгөлөлт эдлүүлэхээр гэрээгээр тохиролцсон бол дээрх хөнгөлөлтийг хасч тооцоолсон цэвэр дүнгээр бүртгэлд тусгана.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж, бүртгэнэ. Авлагын үлдэгдэл нь түүний нэрлэсэн үнээс найдваргүй авлагад байгуулсан хасагдуулга ба бусад заасан тохируулгыг хассан дүнгээр илэрхийлэгдэнэ.

4.2.2 Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн өдрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ юм. Хэрвээ санхүүгийн хөрөнгийн зах зээл идэвхтэй биш бол үнэлгээний аргыг ашиглан бодит үнэ цэнийг тогтоох ба ямар арга хэрэглэх талаар нягтлан бодож бургэлийн бодлогын баримт бичигт тусгаж мөрдөнө.

“ЖУУЛЧИН ДИОТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй тохиолдолд өргөөр нь бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, хэмжилт нь түүний ангиллаас шалтгаалах тул үнэт цаасны ангиллыг тодорхойлсны дараа үнэлнэ. Дараах ангилын дагуу бүртгэнэ.

Aшиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжиж, бүртгэнэ. Энэ нь тухайн санхүүгийн хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгөн дунтэй тэнцүү байна. Харин санхүүгийн хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотоой брокерийн шимтгэл, буцаагдахгүй татвар, үнэт цаасны арилжааны шимтгэл зэргийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр дахин үнэлэх

ба бодит үнэ цэнд гарсан өсөлт, бууралтыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Энэ ангиллын орийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө.

Бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр дахин үнэлэх ба бодит үнэ цэнд гарсан өсөлт, бууралтыг эздийн өмчийн дансанд бүртгэж, тайлант хугацааны бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Энэ ангиллын өрийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцоолж, тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв энэ ангиллын санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бурсан бодитой нотолгоо байгаа бол үнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Хорогдуулсан өргөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өргөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэ ангиллын санхүүгийн хөрөнгийг санхүүгийн тайланд хорогдуулсан өргөөр үнэлж, толилууна. Хэрэв энэ ангиллын санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бодитой нотолгоо байгаа бол үнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хорогдуулсан өргөөр илэрхийлэх санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээнд заасан мөнгөн төлбөрийг авч, өгөөж хүртэхийн тулд хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загварт нийцэх ба гэрээний дагуу санхүүгийн хэрэгслийн үлдсэн дун ба хүү заасан хугацаанд төлөгддөг байх гэсэн хоёр нөхцөл хангагдсан байна.

4.2.3 Дансын ба бусад өглөг

Компанийн одоо байгаа өр төлбөрийг төлж барагдуулснаар эдийн засгийн үр ашигийг агуулж байгаа хөрөнгө ноец буурах магадлалтай, хэмжигдэх бүрэн боломжтой өр

телбөрийг хүлээн зөвшөөрч балансад тусгана. Санхүүгийн байдлын тайланд тайлагнасан дансын үнэ нь дараах санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөс бурдэж байна.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4.2.4 Санхүүгийн хөрөнгө

	2023/12/31	2022/12/31
Мөнгөн хөрөнгө	292,559,555	39,161,715
Дансны болон бусад авлага	2,789,824,340	2,455,672,538
Нийт санхүүгийн хөрөнгө	3,082,383,915	2,494,834,253

4.2.5 Санхүүгийн өр төлбөр

	2023/12/31	2022/12/31
Дансны ба бусад өглөг	25,246,045	10,650,930
Нийт санхүүгийн өр төлбөр	25,246,045	10,650,930

4.2.6 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Удирдлага нь Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж бэлтгэх үүрэгтэй байdag.

Компани нь үйл ажиллагааны явцад дараах санхүүгийн эрсдэлүүдэд өртөх магадлалтай.

Үүнд:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Төлбөрийн чадварын эрсдэл

а) Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь компанийд санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг. Компани тайлант хугацаанд материаллаг хэмжээний дансны болон бусад авлагатай ба зээлийн эрсдэлд өртөх магадлалтай.

б) Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл нь тухайн байгууллагад учирч болох гадаад хүчин зүйл буюу банкны салбар, хөрөнгийн зах зээлийн үнийн хэлбэлзэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, хууль зүй, татварын бодлого гэх мэт зах зээлийн орчноос хамаарч байгаа эрсдэл юм.

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм. Компани нь хүүгийн түвшний эрсдэлд өртөөгүй.

в) Төлбөрийн чадварын эрсдэл:

Төлбөрийн чадварын эрсдэл нь ажлын капитал, зээлийн хэрэглүүр дэх санхүүгийн төлбөр, үндсэн өрийг төлж барагдуулахтай холбоотой үүсдэг. Энэ нь Компани санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл юм.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компанийн баримтлах бодлого бол үүргийн гүйцэтгэлийн хугацааны эцэст түүнийг барагдуулах хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. Компани 2023 оны 12 сарын 31-нээр төлбөрийн чадварын эрсдэлд өртөөгүй.

4.3 Урьдчилсөн төлсөн зардал, тооцоо

Компани бэлтгэн нийлүүлэгчдэд урьдчилан төлсөн ирээдүйд зардлаар эсвэл хөрөнгөөр хаагдах мөнгөн бус хөрөнгийг ортгөөр нь хуримтлуулан бүртгэдэг.

4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний тооцоолсон үлдэх өргтийг харгалзан ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцоолон, уг элэгдлийн дүнгээр үндсэн хөрөнгийн өргтийг бууруулдаг.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах эсвэл хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн үр өгөөжгүй болсон үед нь данснаас хасдаг. Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз эсвэл гарзыг тухайн жилийн дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

Үндсэн хөрөнгүүдэд дараах хувь хэмжээгээр элэгдэл байгуулсан болно.

Үндсэн хөрөнгийн ангилал	Хувь хэмжээ	Ашиглагдах хугацаа
Тоног төхөөрөмж	10%	10
Тээврийн хэрэгсэл	10%	10
Тавилга, эд хогшил	10%	10
Компьютер, дагалдах хэрэгсэл	50%	2

4.5 Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлоходоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

Компани богино хугацаат түрээс болон бага үнэ цэнэ бүхий хөрөнгийн түрээсээс бусад бүх түрээсийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг аргыг хэрэглэнэ. Компани түрээсийн төлбөрийг төлөөлж “түрээсийн өр төлбөр”-ийг хүлээн зөвшөөрч, тодорхойлсон хөрөнгийг түрээслэн ашиглах эрхийг төлөөлж “ашиглах эрхтэй хөрөнгө”-ийг хүлээн зөвшөөрнө.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Компани ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэх өдөр эхлэн хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасч өргөөр нь хэмжих бөгөөд түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь хүлээн зөвөөрөгдсөн түрээсийн өр төлбөр, анхны шууд өртөг, түрээсийн урамшууллыг хүлээн авахаас өмнө буюу өмнөх өдрөөс эхлэн хийсэн түрээсийн төлборууд багтана.

Компани түрээсийн хугацааны туршид төлөх төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг түрээс эхлэх өдөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр гэдэгт аливаа урамшуулалт хөнгөлөлтийг хассан түрээсийн тогтмол төлбөрөөс гадна хувь хэмжээнээс хамаарах хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамааруулан авч үзнэ.

4.6 Эздийн омч

4.5.1 Хувь нийлүүлсэн хоронго

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж бүртгэдэг. Хувьцаа эзэмшигчдээс нэмж оруулсан хөрөнгө оруулалтаар эздийн өмчийг нэмэгдүүлж бүртгэнэ. Компани үүсгэн байгуулагдсанас хойш хугацаанд хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд хуримтлуулан бүртгэдэг.

4.5.2 Ногдол ашиг

Компани хувьцааг эзэмшигчидээ мөнгө болон бусад хөрөнгөөр, эсвэл хувьцаагаар ногдол ашиг хувиарладаг. Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

4.6 Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрөөр зарласан ханшийг ашиглаж, “анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр” хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд тайлант хугацааны эцсийн өдрөөр Монголбанкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэл хийдэг.

Түүхэн өргөөр илэрхийлэгдсэн гадаад валютаарх мөнгөн бус зүйлсийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийдэггүй. Ханшийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрүүг орлогын дэлгэрэнгүй тайланд ханшийн тэгшитгэлийн олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг.

4.7 Үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг магадалдаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвгөөрнө.

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

4.8 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлого нь хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит унэ цэнээр хэмжигдэнэ. Компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал онцлог бөгөөд орлого ба өргөт зардлыг бодитоор хэмжих боломжтой үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

4.8.1 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Компани нь амласан бараа, үйлчилгээгээ худалдан авагчид нийлүүлснээр гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Худалдан авагч нь тухайн хөрөнгийн хяналтыг олж авсан тохиолдолд хөрөнгийг нийлүүлсэн гэж үзнэ.

Гэрээний орлого гэдэг нь гэрээгээр зөвшөөрсөн орлогын анхны дүн болон орлого авчрах магадлалтай дунг нь найдвартай хэмжих боломжтой гэрээт ажлын зерүү, нэхэмжлэл болон урамшуулал төлбөрийг хэлнэ.

4.8.2 Хүүгийн орлого

Хүүгийн орлогод сүл чөлөөтэй, эргэлтэнд ороогүй мөнгөн хөрөнгөд тооцсон хүүний орлого хамаарах ба үүнийг тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрдөг. Хүүгийн орлогыг гэрээ болон мөрдөж байгаа хүүгийн түвшинг ашиглан тооцож орлогын тайландаа хуримтлуулж бүртгэдэг.

4.8.3 Бусад орлого

Бизнесийн хэвийн бус нохцөлд үүссэн бөгөөд эдийн засгийн өгөөжийг найдвартай хэмжих боломжтой, үүнийг аж ахуйн нэгж байгууллага хүртэх магадлалтай үед бусад орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

4.9 Өртөг, зардал хүлээн зөвшөөрөлт

4.9.1 Зардал

Тайлант хугацааны туршид байгууллагын үндсэн болон бусад үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотойгоор хөрөнгө буурах, өөр ямар нэг байдлаар ашиглагдах, эсвэл өр төлбөр нэмэгдэх байдлаар эдийн засгийн үр дунг хорогдуулах ажил гүйлгээ үүсгэх явдал юм.

Зардлыг дэлгэрэнгүй орлогын тайландаа зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлagnадаг. Үйл ажиллагааны зардалд срөнхий ба удирдлагын болон борлуулалт, маркетингийн зардлууд хамаарна.

Санхүүгийн зардалд бүх төрлийн хүүгийн зардал, зээлийн шимтгэл, зээлтэй холбоотой үүссэн бусад зардал хамаарна. Харин бусад зардалд үйл ажиллагааны зардлаас бусад хандив, алданги, торгууль, найдваргүй авлагын зардал орно.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4.10 Болзошигүй өр төлбөр ба уурэг хариуцлага

Аж ахуйн нэгж нь болзошигүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэхгүй. Эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлал нь бага байхаас бусад тохиолдолд энэхүү стандартаар шаардсанчлан, болзошигүй өр төлбөрийг тодруулна.

Компани нь 2023.12.31-нээр болзошигүй өр төлбөрийн үлдэгдэлгүй.

4.11 Холбоотой талууд

НББОУС 24 Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанийтай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол

Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгж компанийтай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанийд хамаардаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой;
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группийн нэг аж ахуйн нэгжийн талын хамтын хяналттай компани бол;
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Дээр тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- Дээр тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Компанийн холбоотой этгээдэд Монгол улсын Компанийн тухай хуулийн 99.1 дэх заалтад тодорхойлсон хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагууд болон тэдний гэр бүл, хамаатан садангууд, компанийн ажиллагсад зэрэг иргэн, хуулийн этгээд хамаарна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компанийн холбоотой талуудад дараах байгууллагууд хамаарч байна.

Харилцан холбоо	Холбоотой талууд
Хувьцаа эзэмшигчид	Таванбогд холдингс ХХК Радар фанд ХХК
Нэг толгой компанийтай охин компаниуд	“Таван богд трейд” ХХК-ийн охин компаниуд
Гүйцэтгэх удирдлага	Ц.Отгонбаяр

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Холбоотой талуудтай хийсэн тооцооны улдэгдэл дараах байдалтай байна.

Холбоотой талууд	Данс	2023/12/31	2022/12/31
Таванбогд холдингс ХХК	Авлага	-	2,433,763,633
Таван Богд ХХК	Авлага	1,387,035	-
Жуулчин ХХК	Авлага	-	1,200,000
Таван Богд Солюшнс ХХК	Авлага	338,172	-
Ц.Отгонбаяр	Авлага	288,896	-
	Өглөг	80,000	-
Нийт авлага		2,014,103	2,434,963,633
Нийт оглог		80,000	-

Голлох удирдлагын тайлант оны цалин хөлс, урамшуулал, холбогдох бусад тэтгэмжийн зардал дараах байдалтай байна.

Зардал	2023/12/31	2022/12/31
Цалин хөлс урамшуулал	59,389,662	
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	12,160,383	
Нийт	71,550,045	

4.12 Капиталын удирдлага

Компанийн капиталын удирдлагын зорилгоор, капиталд зарцуулсан капитал, хөрвөх нөхцөлтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Компанийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

4.13 Балансын дараах үйл явдал

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тайлагналын өдрөөс хойш аудитын дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд уг санхүүгийн тайланд нөлөөлөхүүц материалыг дун бухий ажил гүйлгээ гараагүй бөгөөд нөлөө бухий шийдвэр болон томоохон үйл явдал тохиолдоогүй.

“Жуулчин дюти фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3-р сарын 20-ны өдрийн ээлжит хурлын ТҮЗ2024-03/02 дугаар тогтоолоор Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 30-ны өдөр хуралдуулахаар зарласан байна.

4.14 Татвар

4.14.1 Орлогын албан татвар

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Тайлант жилийн татвар гэдэг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод тайлагналын өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын хүлээгдэж буй өр эсвэл авлага болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бурдэнэ.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлагналын болон татварын зорилгоор тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн хооронд үүссэн түр зөрүүтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 0-6 тэрбум тогрогийн албан татвар ногдуулах орлогод 10%-иар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлогод 25%-иар татвар ногдуулан төлхөөр шинэчилсэн. Мөн жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах, согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох, газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулахаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар орлогын албан татвар төлнө.

4.14.2 Нэмэгдсэн ортгийн албан татвар

Компани нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч бөгөөд импортолсон, үйлдвэрлэсэн, борлуулсан бараа бүтээгдэхүүн болон үзүүлсэн ажил үйлчилгээний борлуулалтын орлогоос 10 хувиар тооцож нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг.

4.14.3 Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүний орлогын албан татварыг ажиллагсдын цалин болон түүнтэй адилтгах орлого мөн гэрээт ажил гүйцэтгэгчийн хөлснөөс 10 хувиар тооцон ногдуулдаг. Ажил олгогч эсвэл үйлчилгээ хүлээн авагч нь ажиллагчдын цалин болон гэрээт ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татварыг суутгаж, ажиллагсад болон гэрээт ажилчдын нэр дээр татварын байгууллагад шилжүүлдэг.

4.15 Нийгмийн даатгалын шимтгэл

Ажил олгогч болон байгууллага нь ажиллагсдын цалин болон түүнтэй адилтгах орлого мөн гэрээт ажил гүйцэтгэгчийн хөлснөөс даатгуулагч 11.5 хувиар, ажил олгогч 12.5 хувиар нийгмийн даатгалын шимтгэл суутгадаг ба сар бүрийн цалин болон үйлчилгээний хөлснөөс суутгах нийгмийн даатгалын шимтгэлийн дээд хэмжээ нь 483,000 төгрөг болсон. Ажиллагсдын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон үйлчилгээг хүлээн авагч суутгаж нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлдэг.

“ЖУУЛЧИН ДИОТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

	12/31/2023	12/31/2022
Касс дахь бэлэн мөнгө (MNT)	-	360,500
Касс дахь бэлэн мөнгө (USD)	-	344,460
Жижиг мөнгөн сан	-	383,700
	<hr/>	<hr/>
	1,088,660	1,088,660

Харилцах ХААН банк (MNT) 5063127814	87,274,074	8,192,783
Харилцах ХАС (MNT) 5001360230	-	-
Харилцах ХХБ (MNT) 453039226	79,693	90,693
Харилцах Голомт (MNT) 8115101299	177,290,319	371,627
Харилцах ХААН (USD) 5063127825	7,503,791	15,458,573
Харилцах ХАС банк (USD) 5002099883	1,077,198	1,129,243
Харилцах ХХБ (USD) 453039237	12,539,805	12,676,404
Харилцах Голомт (USD) 8115101300	6,794,674	153,733
Харилцах дансны дүн	292,559,555	38,073,055
Шийт мөнгөн хөрөнгийн дүн	292,559,555	39,161,715

6. ДАНСНЫ АВЛАГА (ЦЭВЭР)

	12/31/2023	12/31/2022
Борлуулалтын авлага	3,269,949	6,510,265
	<hr/>	<hr/>
	3,269,949	6,510,265

7. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

	12/31/2023	12/31/2022
ААНОАТ-ын авлага /TT02/	-	11,000,016
НӨАТ-ын авлага	3,636,378	-
ХХОАТ авлага	371,798	483,465
НДШ-ийн тооцоо	1,608,223	509,932
	<hr/>	<hr/>
	5,616,400	11,993,413

8. БУСАД АВЛАГА

	12/31/2023	12/31/2022
Компани хоорондын авлага	2,800,000,000	2,433,763,633
Ажиллагчдаас авах авлага	46,225,331	972,778
Бусад авлага	23,089,674	15,398,640
Бусад найдвартгүй авлагын хасагдуулга	(36,535,263)	-
	<hr/>	<hr/>
	2,832,779,742	2,450,135,051

9. БАРАА МАТЕРИАЛ

	12/31/2023	12/31/2022
Бараа	703,322,568	887,714,195
Хангамжийн материал	2,833,330	306,044
Маркетинг идэвхжүүлэлт	-	434,698
	<hr/>	<hr/>
	706,155,898	888,454,937

**“ЖУУЛЧИН ДОТИ ФРИЙ” ХК
САНХУҮТГИЙН ТАЙЛАННИЙ ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУТААР САРЫН 31**

10. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ (ГООЦОО)

	12/31/2023	12/31/2022
Урьдчилж төлсөн тооцоо-Бусад	6,175,424	4,214,737
Урьдчилж төлсөн тооцоо-Бараа	2,590,670	2,430,284
Урьдчилж гарсан зардал-Ажил үйлчилгээ	1,387,035	4,050,000
	<u>10,153,129</u>	<u>10,695,021</u>

11. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Өргөт	Тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгслэл	Тавихаа эд зотшил	Комьюнтр дагалдах хэрэгслэл	Нийт
1/1/2023	101,919,071	160,800,000	86,571,912	25	349,291,008
Хувалдаж авсан			1,827,890	16,283,540	18,111,340
12/31/2023	101,919,071	160,800,000	88,399,712	16,283,565	367,402,348
Хүримтгэлдсан элэгдэл					
1/1/2023	9,410,374	85,403,162	37,849,113	-	132,662,649
	10,223,343	16,071,191	8,755,192	6,816,364	41,866,090
Тайлант жилд байгуулсан	19,633,717	101,474,353	46,604,305	6,816,364	174,528,740
12/31/2023					
Үзүүлэлт өргөт					
12/31/2023	82,285,354	59,325,647	41,795,407	9,467,201	192,873,608

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

12. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Өртөг	Программ хангамж	Нийт
1/1/2023	8,025,620	8,025,620
Нэмэгдсэн		
Залруулга хийсэн		
12/31/2023	8,025,620	8,025,620
Хуримтлагдсан хорогдол		
1/1/2023	4,324,590	4,324,590
Тайлант жилд байгуулсан	1,266,051	1,266,051
Залруулга хийсэн		
1/1/2023	5,590,640	5,590,640
Үлдэгдэл өртөг		
12/31/2023	<u>2,434,980</u>	<u>2,434,980</u>

13. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ

	12/31/2023	12/31/2022
Хойшлогдсон татварын хөрөнгө	34,653	-
	<u>34,653</u>	<u>-</u>

14. ДАНСНЫ ӨГЛӨГ

	12/31/2023	12/31/2022
Дотоодын байгууллагад өгөх өглөг	22,099,770	2,121,807
	<u>22,099,770</u>	<u>2,121,807</u>

15. ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ

	12/31/2023	12/31/2022
Цалингийн өглөг	13,677,221	8,410,309
	<u>13,677,221</u>	<u>8,410,309</u>

16. ТАТВАРЫН ӨГЛӨГ

	12/31/2023	12/31/2022
ААНОАТ-ын өглөг	24,489,607	-
НӨАТ-ын өглөг	-	1,919,767
ХХОАТ-ынын өглөг	13,572,081	8,901,588
	<u>38,061,688</u>	<u>10,821,354</u>

17. НОГДОЛ АШГИЙН ӨГЛӨГ

	12/31/2023	12/31/2022
Ногдол ашгийн өглөг	977,156,755	977,156,755
	<u>977,156,755</u>	<u>977,156,755</u>

18. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

	12/31/2023	12/31/2022
Урьдчилж орсон орлого	333,537	-
	<u>333,537</u>	<u>-</u>

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. НӨӨЦ/ӨР ТӨЛБӨР/

	12/31/2023	12/31/2022
Нөөц /өр төлбөр/	-	1,200,000
	<u>-</u>	<u>1,200,000</u>

20. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨГЛӨГ

	12/31/2023	12/31/2022
Бусад өглөг	3,146,276	8,529,123
	<u>3,146,276</u>	<u>8,529,123</u>

21. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨР

	12/31/2023	12/31/2022
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	38,803,778
	<u>-</u>	<u>38,803,778</u>

22. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

	12/31/2023	12/31/2022
Хувийн өмч	13,072,400	13,072,400
	<u>13,072,400</u>	<u>13,072,400</u>

23. ХУРИМТЛАГДСАН ШИГ

	12/31/2023	12/31/2022
Хуримтлагдсан ашиг	2,978,330,266	2,567,164,265
	<u>2,978,330,266</u>	<u>2,567,164,265</u>

24. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)

	12/31/2023	12/31/2022
Бараа борлуулалт	1,605,820,208	392,406,829
Борлуулалтын буцаалт	(70,480)	-
	<u>1,605,749,728</u>	<u>392,406,829</u>

25. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

	12/31/2023	12/31/2022
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	762,701,099	200,587,968
	<u>762,701,099</u>	<u>200,587,968</u>

26. ХҮҮНИЙ ОРЛОГО

	12/31/2023	12/31/2022
Зээлийн хүүний орлого /компани хооронд/	285,947,931	-
Хүүний орлого /харилцах/	1,365,988	-
	<u>287,313,919</u>	<u>-</u>

27. БУСАД ОРЛОГО

	12/31/2023	12/31/2022
Бусад	2,733,128	5,921,684
	<u>2,733,128</u>	<u>5,921,684</u>

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

28. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Цалин урамшуулал	168,626,409	56,649,353
Нийгмийн даатгалын шимтэл	21,452,821	7,165,166
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	12,412,507	14,257,867
Албан томилолт	2,677,839	2,967,547
Бичиг хэрэг	1,125,038	152,942
Шуудан холбооны зардал	2,579,965	900,982
Мэргэжлийн үйлчилгээ	14,531,000	10,387,533
Ажилчдын сургалт, заавар, чиглүүлэг, хурал, уулзалт	630,000	-
Даатгал	5,013,896	2,538,265
Засвар үйлчилгээ	10,252,708	604,000
Элэгдэл	28,261,413	19,044,796
Түрээсийн зардал	28,318,734	11,070,000
Харуул хамгаалалтын зардал	1,239,440	132,890
Тээвэр шатахуун	11,822,181	8,554,265
Хүлээн авалтын зардал	-	591,800
Зар, сурталчилгааны зардал	2,362,500	1,160,000
Хөдөлмер хамгаалал	54,600	-
Бусад зардал	4,477,492	3,418,631
	<u>315,838,542</u>	<u>139,596,037</u>

*Бусад зардалд хангамж, ажилийн дүнг идэвхижүүлэх, шимтэл, бэлэг дурсгал болон бусад зардал байна.

29. БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Цалин урамшуулал	61,806,773	29,335,845
Нийгмийн даатгалын шимтэл	8,408,691	7,614,991
Албан татвар, төлбөр хураамж	3,958,388	709,231
Бичиг хэрэг	949,200	541,680
Шуудан холбоо	4,658,757	2,467,055
Аппиглалтын зардал	5,517,434	31,660
Засварын зардал	6,612,022	1,815,000
Элэгдлийн зардал	14,870,728	11,133,838
Түрээсийн зардал	59,391,558	35,150,000
Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын зардал, дотоод хэрэг	3,494,679	1,297,000
Тээврийн зардал	3,095,000	2,460,000
Маркетинг, идэвхижүүлэлтэй холбоотой зардал	434,698	232,000
ХАБЭА-тай холбоотой бусад -АБ	-	267,400
Бусад зардал	9,799,154	3,892,052
	<u>182,997,083</u>	<u>96,947,752</u>

*Бусад зардалд хангамж, баяр ёслол, шимтэл, бэлэг дурсгал болон бусад зардал байна.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ГАДААД ВАЛЮТЫН ХАНИШИЙН ЗӨРҮҮГИЙН ОЛЗ, ГАРЗ

	12/31/2023	12/31/2022
Валютын ханишийн зөрүүгийн бодит олз	6,044,137	10,796,222
Валютын ханишийн зөрүүгийн бодит бус олз	59,230,033	391,930,270
Валютын ханишийн зөрүүгийн бодит гарз	(6,646,120)	(4,396,984)
Валютын ханишийн зөрүүгийн бодит бус гарз	<u>(58,820,957)</u>	<u>(2,389)</u>
	<u>(192,908)</u>	<u>398,327,119</u>

31. БУСАД ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Алданги, торгуулийн зардал	79,612,623	-
Бусад	737,500	-
Найдваргүй авлагын зардал	36,535,263	-
Хөрөнгө акталж устгасны зардал	880,000	1
Бараа материалын үнэ цэнийн бууралтын зардал	280,345	-
Бараа материал акт, устгал	77,264,247	-
Бусал зарлал	<u>7,708,584</u>	<u>963,650</u>
	<u>197,518,563</u>	<u>963,651</u>

32. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ДАНСНААС ХАССАНЫ ГАРЗ

	12/31/2023	12/31/2021
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	-	583,663
	<u>-</u>	<u>583,663</u>

33. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	12/31/2023	12/31/2022
Орлогын албан татварын зардал	35,489,623	38,754,022
Хойшлогдсон татварын зардал	(38,838,431)	
Бусдад сүүтгүүлсан татварын зардал	28,731,387	
	<u>25,382,580</u>	<u>38,754,022</u>

34. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	12/31/2023	12/31/2022
<i>Татварын омнох ашиг (алдагдал)</i>	436,548,581	359,143,886
Татварын омнөх ашгаас тооцсон татварын зардал 10%	43,654,858	35,914,389
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нелөөлөл	19,751,856	2,839,633
Бусад байнгын зөрүүгийн бууруулах дүн	(28,731,392)	
Түр зөрүүгийн нелөөлөл	(9,292,743)	
<i>Нийт орлогын татварын зардал</i>	<u>25,382,580</u>	<u>38,754,022</u>